


**ДУНДГОВЬ АЙМГИЙН
ӨНДӨРШИЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2023 оны 02 сарын 15 өдөр

Дугаар 1/22

Бөхт

Үнэлгээний хороо байгуулах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.9, 45 дугаар зүйлийн 45.3, 46 дугаар зүйлийн 46.1.1 дэх заалт, Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 02 дугаар сарын 08-ны өдрийн 87 дугаар тогтоолыг тус тус үндэслэн **ЗАХИРАМЖЛАХ** нь:

1. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2023 онд хийгдэх “Баяр наадмын талбайн асар шинээр барих ажил”-ын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үүрэг бүхий үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Үнэлгээний хорооны дарга М.Цэвэгдорж (Бөхт багийн Засаг дарга)

Гишүүд Б.Амгаланжаргал (Засаг даргын Тамгын газрын
дарга)

Ө.Бямбажаргал (Иргэний төлөөлөл)

Д.Номин-Эрдэнэ (Хүүхдийн цэцэрлэгийн эрхлэгч)

Нарийн бичгийн дарга О.Амгалантөр (Нийгмийн бодлого
хариуцсан мэргэжилтэн)

2. Хууль тогтоомжид заасны дагуу баримт бичгийг бүрдүүлэн, сонгон шалгаруулалтыг зохион байгуулж ажиллахыг үнэлгээний хорооны дарга (М.Цэвэгдорж)-д, архивын нэгж үүсгэн баримтжуулж ажиллахыг нарийн бичгийн дарга (О.Амгалантөр)-д даалгасугай.

3. Нийтийн албанад нийтийн болон хувийн ашиг сонирхлын зөрчлийг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлийн тухай хуулийн хэрэгжилтийг ханган, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлж ажиллахыг үнэлгээний хороонд даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

У.АЛТАНХҮҮ



D:\My documents\A Zahiramj-2023.docx

4823010046